

БАТЛАВ  
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА И.БАТТӨГС

2024 оны ... дүгээр сарын ...

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

1	Үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль</li><li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль</li><li>- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль</li></ul>
2	Байршил	<ul style="list-style-type: none"><li>- Баянзүрх дүүргийн 33 дугаар хороо, Гачуурт голын хөндийн Бага Шар хоолойн Бэрх төгөл</li></ul>
3	Зорилго	<ul style="list-style-type: none"><li>- Орон нутгийн хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулж өнөөгийн төлөв байдалд үнэлэлт, дүгнэлт өгч тэдгээрт учирч буй болон ирээдүйд учирч болох аюул, эрсдэлд дүн шинжилгээ хийж хэтийн төлөвийг тодорхойлно.</li></ul>
4	Зорилт	<ul style="list-style-type: none"><li>- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй"-г баримтлан орон нутгийн хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулна.</li><li>- Төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг харгалзан тооцож, дүүргийн газар зохион байгуулалт, бусад төлөвлөлттэй уялдуулсан байна.</li></ul>
5	Ажил гүйцэтгэх үе шат, хугацаа	<ul style="list-style-type: none"><li>- Менежментийн төлөвлөгөө боловсруулах орон нутгийн хамгаалалттай газрын онцлог, биологийн олон янз байдал, хамгаалах шаардлагатай ховор зүйлүүд, уст цэг, булаг шанд, байгаль орчинд гарч буй өөрчлөлтийн байдалд үнэлгээ хийх;</li><li>- Орон нутгийн хамгаалалттай газар нутгийг дүүргийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, бэлчээр, газар, байгалийн баялаг ашиглалт, хэвийн төлөв, хэрэгцээ шаардлагад үнэлгээ хийх;</li><li>- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт амьдардаг иргэд, малчид, талуудын мэдлэг, хандлага, дадал хэвшил, хүний үйл ажиллагаанаас биологийн олон янз байдалд үзүүлж буй нөлөөллийн байдалд талуудын оролцоотой үнэлгээ хийх;</li><li>- Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөний үр ашиг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, орон нутгийн талуудын үзүүлэх дэмжлэгийг тоон болон чанарын аргаар судлан дүгнэж улмаар сумын нутаг дэвсгэрийн хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн захиргаа нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах;</li><li>- Нутгийн иргэдэд түшиглэсэн хамгааллын менежментийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нутгийн</li></ul>

		<p>иргэд байгалиа хамгаалах, түүнээс ашиг хүртэн амьжиргаагаа дээшлүүлэх боломжуудыг илрүүлж хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлох;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн хамгаалалттай газар нутагт иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжийг судлах, менежментийг төлөвлөх;</li> <li>- Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн удирдлага зохион байгуулалт, тогтвортой санхүүжилтийн орчин бүрдүүлэх шинэлэг арга барилыг төлөвлөгөөнд тусгах;</li> <li>- Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв боловсруулах;</li> <li>- Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн менежментийн чадавхыг сайжруулах, байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлал, нөхөрлөлийг чадвухжуулах арга боломжийн талаар зөвлөмж боловсруулна;</li> <li>- Нутгийн өөрөө удирдах ёс, үйл ажиллагааны зарчимд суурилсан орон нутгийн хамгаалалттай газар нутгийн менежментийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн эрх үүрэг, талуудын оролцооны хэлбэрийг тодорхойлох;</li> <li>- Менежментийн төлөвлөгөөнд талуудын санал авч эцэслэн боловсруулж батлуулах.</li> </ul>
6	Ажил гүйцэтгэгчид тавих шалгуур	<ul style="list-style-type: none"> <li>- Ажил гүйцэтгэх баг нь 6-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба байгаль хамгаалал, орон нутгийн хамгаалалттай газар нутгийн судалгаа, менежментийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр ажилласан туршлагатай баг байна.</li> </ul> <p>Хуулийн этгээдэд тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зөвлөх үйлчилгээний өдөр тутмын ажил болон тус ажлыг хянан хариуцан ажиллах ажилтантай байх;</li> <li>- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж байсан туршлагатай байх ба байгууллага зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна;</li> </ul> <p>Үүнд:</p> <p>Судалгааны багийн ахлагч 1 хүн</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгаль орчны чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;</li> <li>- Байгаль хамгааллын олон талт асуудлууд, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн судалгаа, менежментийн төлөвлөгөө, үр ашигт байдлын үнэлгээ хийж байсан, байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх;</li> <li>- Хуваарийн дагуу үр дүнд суурилсан гүйцэтгэлтэй байх</li> </ul> <p>Судалгааны багийн бүрэлдэхүүн 5 хүн</p> <ul style="list-style-type: none"> <li>- Экологич, биологийн олон янз байдлын судлаач - байгаль орчны суурь нөхцөл байдлын судалгаанд үндэслэн экологи, экосистемийн тэнцвэрт байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын чиглэлээр ажиллаж байсан чадвартай туршлагатай байх;</li> <li>- Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн эсвэл газар зохион байгуулагч - Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн</li> </ul>

		<p>төлөвлөгөөг МИРАДИ программаар боловсруулж байсан туршлагатай байх; газарзүйн мэдээллийн систем дээрх мэдээ датаг нэгтгэн боловсруулах, мэдээллийн сан үүсгэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засаг-бизнес төлөвлөлтийн мэргэжилтэн; Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн механизмыг хэрэгжүүлэх мэдлэг туршлагатай байх; ТББ, хэвийн хэвшил, иргэдтэй нээлттэй, хүртээмжтэй ажиллах чадвартай байх; орон нутгийн ард иргэдийн амьжиргаа дээшлүүлэх, төлөвлөлт хийх бизнес төлөвлөгөө боловсруулж байсан туршлагатай байвал давуу тал болно;</li> </ul>
7	Боловсруулах, тайлагнах, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Зөвлөх ажил үйлчилгээ гүйцэтгэх аргачлал, ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж захиалагч талаар баталгаажуулна;</li> <li>- Менежментийн төлөвлөө боловсруулахад шаардлагатай бүх талын үнэлгээ, судалгааг хийж гүйцэтгэнэ;</li> <li>- Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулна.</li> </ul>

ХЯНАСАН:  
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

  
Н.БИЛЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:  
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ  
ТАСГИЙН ДАРГА

  
М.БАТ-ЭРДЭНЭ